



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/556

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчид бүртгэлтэй авто машинуудыг татан төвлөрүүлэх, шилжүүлэх, хуваарилах, ашиглалтын хугацаа дууссан хөдлөх хөрөнгө хүлээж авах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
дарга:

Г.Лхагвахатан

Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд:

Ц.Бат-Эрдэнэ

Автотээврийн төвийн дарга

С.Наранхүү

Автотээврийн төвийн Техникийн  
хяналтын үзлэгийн техникч

Г.Баттулга

Орон нутгийн өмчийн газрын жолооч,  
Нярав

Нарийн бичгийн  
дарга:

Ш.Цамбасүрэн

Орон нутгийн өмчийн газрын  
мэргэжилтэн

2.Авто машины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан орон нутагт суудлын автомашин ашиглах эрх бүхий аймаг, сумын Засаг дарга, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа орон нутгийн өмчид бүртгэлтэй авто машины талаарх мэдээллийг бүх төсвийн захирагч, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нараас гаргуулан авч, нэгтгэн аймгийн Засаг даргад танилцуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга, ажлын хэсгийн ахлагч (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

3.Орон нутгийн өмчид бүртгэлтэй авто машиныг ажлын хэсгээс тогтоосон

2.

хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх төсвийн Захирагч, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт даалгасугай.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ